

Зүүн хойд азийн интеграцид Орос, Хятадын стратегийн түншлэлийн гүйцэтгэх үүрэг

Ц.Баатар*

Энэхүү өгүүлэлд Зүүн хойд Азид Орос, Хятадын явуулж буй бодлого үйл ажиллагааны үндсэн чиглэл, ялангуяа худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруултын салбарын хамтын ажиллагаа, түүний өнөөгийн болон цаашдын төлөв байдлыг хураангуйлан авч үзсэн. Хоёр хөрш маань энэ бүс нутагт дангаараа эдийн засгийн өрсөлдөөнд орохоосоо илүүтэй зах зээлийн бүсчилсэн хөгжилд тулгуурлаж, бодлого үйл ажиллагаагаа аль болох уялдуулан зохицуулах болсныг тал бүрээс нь харуулж, дүн шинжилгээ хийхийг оролдсон.

The Peace and stability in the Northeast Asia region depends in many ways on the state of relations between the Russian Federation and the People's Republic of China. Then, we must be happy in this region because Russia and China, in pursuing their own interests, sometimes compatibles and sometimes incompatibles, are trying to live peacefully at least now.

The foreign policy of Russia is directed to regain its influence in the Far East, once dominated for the USSR. In doing this, Russia is relying in its huge mining, especially in oil resources. Precisely, Russia is trying to do the same concerning the Northeast Asia. China, on the other side, is making efforts directed to gain influence en the Far East.

* Ц.Баатар ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Америк, Канад судлалын секторын эрхлэгч

ОЛОН УЛС СУДЛАЛ

Russia and China are cooperating side by side in this region. They are discussing and putting in place mega projects of cooperation. The bilateral investments increased constantly. During the visit of Chairman Xi to Moscow important agreements were signed of an amount of 650 billion us dollars. The two sides say that the two countries are "eternal friends and not eternal enemies".

Түлхүүр үгс: Зүүн хойд Ази, ОХУ, БНХАУ, худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа

* * *



Даяршлын өнөөгийн эринд улс орнуудын харилцан хамаарал улам бүр өсөн нэмэгдэхийн хэрээр глобал эдийн засагт нэгдэж, интеграцчлагдах үйл явц эрчимтэй өрнөх болов. Ялангуяа бүс нутгийн орнуудын бие биенээ нөхсөн, харилцан нөхцөлдсөн хамтын ажиллагаа урьд өмнөхөөс илүү түргэн хурдацтай хөгжиж байна. Үүний нэгэн тод жишээ бол ЗХА-ийн бүс нутаг юм. Бүс нутгийн орнууд зөрчил маргаантай асуудлаа хойш тавьж энхийг эрхэмлэж, бүс нутгийн хэмжээнд тулгамдсан асуудлаа хамтран шийдвэрлэх, эдийн засгийн өсөлт хөгжил, уур амьсгалын өөрчлөлт зэрэг асуудалд түлхүү анхаарах болов.

Даяаршлын үр шимийг хүртэж, түүнд идэвхтэй оролцдог дэлхийн олон улс, тэдгээрийн сая сая иргэд хүссэн хүсээгүй өөр хоорондын өчнөөн олон хэлхээ холбоосоор холбогдож, хэн нэг нь хожиж ялах дийлэх тухай ойлголт байхгүй болчихсон тийм цаг үед бид бүхэн амьдарч байна. Ийм нөхцөлд улс орнууд дангаараа эдийн засгийн өрсөлдөөнд орохоосоо илүүтэй зах зээлийн бүсчилсэн хөгжилд тулгуурлах, улс хоорондын гэрээ хэлэлцээрээр эрэгдлээ хуваах сонирхол сүүлийн үед илүү давамгайлах чиг хандлагатай болж ирлээ. ЗХА-ийн бүс нутгийн орнуудад ч гэсэн ийм чиг хандлага ажиглагдах болсны нэг тодорхой жишээ бол энэ бүс нутагт 2000 оны байдлаар ердөө 3 чөлөөт худалдааны хэлэлцээр үйлчилж байсан бол арван жилийн дараа буюу 2010 онд 45 чөлөөт худалдааны гэрээ амжилттай хэрэгжиж, 84 хэлэлцээр яриа хэлцлийн түвшинд явж байна. ЗХА

нь өөрийн эрдэс баялагийн нөөц, эрчим хүчний эх үүсвэрээс гадна үйдвэрлэлийн бүтэц, ажиллах хүчний нөөц, хөрөнгө, технологи болон зах зээлийн хэмжээгээрээ дэлхий дахины анхаарлыг татсан бүс нутаг юм. Энэ бүс нутаг 1990 оны байдлаар дэлхийн нийт экспортын 23%-ийг гаргаж байсан бол 2010 онд 26% болж өсчээ. Дэлхийн ДНБ-ний 20, дэлхийн худалдааны 17,5 нийт хүн амын 22 хувь Хятад, Япон, Өмнөд Солонгос гурван улсад ногдож байна¹.

ЗХА-д төдийгүй дэлхийн хэмжээний их гүрэн болох хоёр хөрш маань ч энэ бүс нутагт тийм уялдуулан зохицуулсан буй бодлого, үйл ажиллагаа явуулж байна.

Нэг. ЗХА-д явуулж буй ОХУ-ын бодлого, үйл ажиллагаа

Дорно зүгт чиглэсэн Москвагийн хандлага нь тус улсын Номхон далайн бүст байр сууриа хүчтэй болгоход чиглэж байна. Ази Номхон далайн бүс нутгийн эдийн засаг эрчимтэй, тогтвортой өсч, эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаа нь дэлхийд онцгой үүрэг гүйцэтгэх болсоны зэрэгцээ олон улсын гео-улстөрийн сонирхлын уулзвар болж энд зөрчилдөөн үүсэх нөхцөл бүрэлдэж байна. ОХУ нь ЗХА дахь өөрийн газар зүйн байршлаа өнөөг хүртэл бүрэн дүүрэн ашиглаж чадаагүй явж ирсэн боловч тус бүс нутаг өнөөдөр энэ улсад нэн тааламжтай өргөн боломжуудыг нээн өглөө. Орос улс Номхон далайн хойд бүст онцгой үүрэгтэй, идэвхтэй үйл ажиллагаа явуулснаар хүчний шинэ хуваарилалтанд шийдвэрлэх нөлөөтэй байх нөхцөл бүрэлдлээ.

Сүүлийн үед дэлхийн эрчим хүч нийлүүлэгчдийн байр суурь, үүрэг оролцоонд өөрчлөлт орох хандлага ажиглагдаж байна. Саудын Араб болон ОХУ хоёр газрын тосны гол нийлүүлэгчид билээ. Дэлхийн хэмжээнд газрын тосны нөөц багасч байгаагаас мөн ирээдүйд экологийн хувьд цэвэр, байгалийн хийн хэрэгцээнд ач холбогдол өгөх хандлага өсөн нэмэгдэж байна. ОХУ-Иран хоёр дэлхийн байгалийн хийн нийт нөөцийн 60 гаруй хувийг эзэмшиж байгаа². Судалгаанаас харахад энэ хэмжээний нөөц нь дэлхийн байгалийн хийн хэрэглээг энэ зууныг дуустал хангах боломжтой байгаа аж. Иймээс ирээдүйд

¹www.wto.org/english/res_e/publications_e/world_tariff.

²www.worldenergyoutlook.org/media/weowebiste/2013

ОЛОН УЛС СУДЛАЛ

газрын тос өөрийн байр сууриа байгалийн хийд алдах нь тодорхой болжээ. Энэ нь Орос улсад Баруун Европ руу эрчим хүчний эх үүсвэр нийлүүлэхийн зэрэгцээ Дорныг хангаснаар, Европоос Номхон далайн бүс хүртэл нөлөөтэй байр суурь эзлэх түүхэн онцгой боломж олгож байна.

2000 оноос Орос улс ЗХА-д чиглэсэн гадаад бодлогоо шинээр харах болж, эрчим хүчний эх үүсвэрийн асар их нөөцдөө тулгуурлан дахин их гүрэн болох, цаашлаад дэлхийн улс төрийн том тоглогчийн байр сууриа сэргээж эхэлсэн билээ.

Байгалийн хий, нефтийн үнийн өсөлтөөр эдийн засгаа тогтоон барьж байгаа Оросын экспортын 80 хувийг ашигт малтмал, импортын 75 хувь нь аж үйлдвэрийн бүтээгдэхүүн эзэлдэг бөгөөд эрчим хүчний бодлогоо өнөөг хүртэл ерөнхийдөө Европын орнууд руу чиглүүлж ирсэн³. Харин сүүлийн үед Хятад, Япон, Өмнөд Солонгос зэрэг ЗХА-ын орнууд руу эрчим хүчний экспортоо чиглүүлж байна.

Тэд эдийн засгийн өсөлт нь зогсонги болсон, хязгаарлагдмал, ханаж байгаа Европын зах зээлийг бодвол энэ бүс нутгийн тогтвортой өсөн нэмэгдэж буй зах зээл Орос улсад илүү өргөн боломж олгоно гэж тооцоолж байна. Саяханы Украины хэрэг явдлаас үүдэн ОХУ ЗХА руу урьд өмнөхөөс илүү эрчимтэй үйл ажиллагаа явуулах болов.

ЗХА-ийн бүс нутаг нь Оросын хувьд зөвхөн эрчим хүч экспортлох шинэ боломж, шинэ зах зээл төдийхөн бус Зүүн Сибирь, Алс Дорнодыг бүс нутгийн эдийн засгийн харилцаанд татан оролцуулах, тэгснээр алс хязгаар нутгаа богино хугацаанд хөгжүүлэхийг зорьж байгаа стратегийнх нь нэг хэсэг юм. Асар их хэмжээний байгалийн хий, газрын тос, нүүрс болон бусад ашигт малтмалын нөөц бүхий Оросын Алс Дорнодын бүс нутаг нь тус улсын эрдэнэсийн сан хөмрөгт тооцогддог. “Дорно зүгт гарах хаалга” гэж Оросын Эзэн Хаан II Александр үүсгэн байгуулж байсан Владивосток хот саяханыг хүртэл ОХУ-ын Алс Дорнодын бүс нутгийн эдийн засаг, нийгмийн сул талыг харуулах жишээ болж байлаа. Гэвч хэдэн жилийн өмнөөс

³Rosstat.WTO

Владивосток хотыг өөрчлөн байгуулахаар томоохон зорилт тавин асар их хэмжээний хөрөнгө оруулалт хийж эхэлснээр өнөөдөр тэнд их бүтээн байгуулалт өрнөж, “Оросын” арал руу тавьж байсан гүүр ашиглалтанд орж, асар том хурлын танхимтай цогцолбор барилгууд, онгоцны буудлын өргөтгөл ашиглалтанд орлоо. Ингэснээр ОХУ анх удаа АПЕК-ийн дээд хэмжээний чуулга уулзалтыг 2012 онд тэнд зохион байгууллаа. Энэ нь Владимир Путинд зүүн бүс нутгаа эдийн засгийн хувьд шинэчлэх, Зүүн Ази, Номхон далайн эдийн засгийн нэгдсэн орон зайд эзлэх Москвагийн шинэ бодлогыг танилцуулах нэн таатай боломж олгосон. Үүнийг бүс нутгийн судлаачид Орос орон ЗХА-даа “эргэн ирлээ” хэмээн дүгнэж байна⁴. АПЕК-ийн дээрхи уулзалт бүс нутагт гео-улстөрийн ямар ерөнхий бүтэц, хандлага гарах, Орос улс энэ бүс нутгийн гол төлөөлөгчид болох Хятад, Япон, Өмнөд Солонгос улсуудтай хэрхэн, ямар харилцаатай байх, Ази-Номхон далайн бүс нутгийн эдийн засагт оролцохдоо Москва ямар боломж, хязгаарлалт, орон зай бий болгох, Зүүн Хойд Азид ямар шинэ гео-улстөрийн нөлөөлөл үзүүлэх зэрэг бүс нутагт ОХУ-ын үүрэг оролцоо ямар байх бол гэсэн олон асуултад хариу өгсөн билээ.

Хоёр. Зүүн Хойд Азид эрчим хүч нийлүүлэгч Орос улс

Дэлхийн эдийн засгийн гол урсгал өнөөдөр Ази-Транс-Атлант/Америк-Европ/-аас Ази-Номхон далай руу буюу Trans Pacific Partnership /TPP/-руу шилжиж байна. Энэ онцгой ач холбогдолтой хөдөлгөөний төвд Зүүн Хойд Ази байгаа юм. Энэ бүс нутаг /Америк, Канадыг оролцуулаад/ дэлхийн ДНБ-ний 50-иас илүү хувийг, мөн дэлхийн валютын нийт нөөцийн 40 хувийг дангаараа эзэлж байна⁵. Ялангуяа Хятадын эдийн засгийн өсөлт нь газрын тос, байгалийн хий, түүхий эдийн их хэмжээний нийлүүлэлтийг өдөөхөд хүргэж байгаа билээ.

Дэлхийн эрчим хүчний хамгийн их хэрэглэдэг 8 орны эхний 5-д ордог Хятад, Япон, БНСУ энэ бүс нутагт байгаа бол харин Зүүн Хойд Азийн эрчим хүчний түүхий эдийн гол нийлүүлэгчийн үүргийг Орос

⁴ Ulyana SHIPITKO Rediscovering Russia in Northeast Asia / Ritsumeikan Annual Review of International Studies, 2012. ISSN 1347-8214. Vol.9, pp. 205-229

⁵ www.worldbank.org/en/region/eap/East-Asia-Pacific-static

ОЛОН УЛС СУДЛАЛ

улс аажмаар эзэлж эхэллээ⁶. Оростой өрсөлдөгч улс тэнд алга, цаашдаа гарах магадлал ч бага. Ялангуяа Арабын орнууд, Персийн булан, Төв Азиас эрчим хүчний экспорт тасалдах үед, эсвэл Хятад, АНУ-ын харилцаа муудах, АНУ Малаккагийн хоолойн усан замыг хаах зэрэг нөхцөл байдал үүсвэл эрчим хүчийг эх үүсвэрийг ОХУ хуурай газраар нийлүүлэх боломжтой учир ихээхэн ач холбогдолтойд тооцогдох болжээ. ОХУ-ын ЗХА-д явуулж буй стратегид шинэ “занарын нүүрс ус төрөгчийн” хэтийн төлөв хэрхэн нөлөөлөхийг одоогоор хэлэхэд эрт байна. Ямар ч байсан өнөөдөр АНУ зэрэг улс орон дэлхийн зах зээлийн байдалд нөлөө үзүүлэхүйц хэмжээний занарын хий, нефть олборлож байна.

Эдгээр өөрчлөлт дэлхийн нүүрс ус төрөгчийн гол сан болох Ойрхи Дорнод ба Персийн булангийн орнууд хийгээд Оросод хэр нөлөөлөх вэ? Цаашлаад бүс нутагт Оросын улс төрийн нөлөөг нь багасгах уу? гэх мэт асуулт одоогоор хариу хүлээж байна.

Гэсэн хэдий ч дээрхи шинэ түлш зарим бүс нутагт нөлөө үзүүлж эхэллээ. АНУ занарын хий олборлож эхэлснээр Ойрхи Дорнодоос авах шингэрүүлсэн хийн хэмжээг хорогдуулав. Үүнтэй холбогдуулан Катар Европын зах зээлд хандан, Европын болзлоор зах зээлд нь гарч байна. Занарын нефть ч аажмаар мэдэгдэхүйц хүчин зүйл болон гарч ирэх төлөв ажиглагдаж эхэллээ. Товчхон хэлэхэд “занарын хувьсгал” нь цаашдаа ЗХА-ийг ч хамрана. Мэдээжээр хэрэглэгчид уламжлалт нефть, байгалийн хийгээс татгалзахгүй. Гэвч уламжлалт энэ эх үүсвэрийн ач холбогдол аажмаар буурах нь тодорхой болж ирлээ.

Оросын хувьд эрчим хүчний эх үүсвэрийн түүхий эд нийлүүлэгч үүрэгтэй болохоос Ази-Номхон далайн бүс нутгийн үйлдвэрлэгчдийн хооронд солбилцсон нарийн сүлжээ, түүнтэй холбоотой интеграцийн хувьд гол оролцогч болж хараахан чадаагүй байна. Хямд ажиллах хүчний нөөцтэй Хятадын аж үйлдвэрийн салбар, өндөр технологи нийлүүлэгч Япон, Өмнөд Солонгосыг бодвол Орос улс бүс нутгийн эдийн засагт тиймч том үүрэг гүйцэтгэдэггүй. Тиймээс ч эдийн засгийн чөлөөт бүсийн гишүүн болоогүй. Мөн хөрөнгө оруулагчдыг хамгаалах

⁶www.worldbank.org/en/region/eap/East-Asia-Pacific-statistics

гэрээнд хараахан нэгдээгүй байна. Гэсэн хэдий ч ОХУ бол Ази Номхон далайн бүсийн улстөрийн тавцанд нөлөө бүхий хэд хэдэн холбоо, эвслүүдийн гишүүн улс билээ. Тухайдбал, 1994 оноос “АСЕАН”-д, 1998 оноос “АПЕК”-т, 2005 оноос “АСЕАН+Орос” зэрэг бүс нутгийн томоохон байгууллагуудын гишүүн болсон юм. Гэвч гишүүн улсын хувьд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа нь төдийлөн харагдаггүй. АПЕК-ийн уулзалтын үеэр л Москва эдийн засгийн ашиг сонирхлын үүднээс Ази-Номхон далайн бүс нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулна гэдгээ илэрхийлсэн⁷. Энэхүү идэхитэй үйл ажиллагаанд Орос, Хятадын хүчин зүйл шийдвэрлэх үүрэг рольтой.

Гурав. ЗХА-д Хятадын явуулж буй бодлого үйл ажиллагаа

Зүүн хойд Азид голлон тоглогч, тоглоомын дүрмийг гартаа авсан орны нэг бол яахын аргагүй Хятад.

Өнөөдөр тус бүс нутагт төдийгүй дэлхийд Хятадын нөлөө нь өдөр ирэх тусам өсөн нэмэгдсээр байна. Хүн ам, хөгжлийн хурдац, дэлхийн зах зээлд нийлүүлж буй бараа бүтээгдэхүүний хэмжээ зэрэг маш олон үзүүлэлтээрээ тэргүүлж байгаа билээ.

Энэ байр суурь, хөгжлийн хурдацаа хэвээр хадгалах нь Хятад улсын туйлын зорилго юм. Хятад улс бүс нутгийн орнуудтай тогтоосон худалдаа эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаанд ихээхэн ач холбогдол өгч энэ бүс нутагт чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах талаар ихээхэн хүчин чармайлт гаргаж ирсний үр дүнд өнгөрсөн онд ЗХА-ийн БНХАУ, Япон, БНСУ-ын удирдлагын түвшинд чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах талаар ярилцаж эхэллээ. Чөлөөт худалдааны гэрээ байгуулагдвал эдийн засгийн багтаамж, хүчин чадлаараа Европын холбоо, Хойд Америкын чөлөөт худалдааны гэрээний орнуудын бүсийн дараа орох эдийн засгийн томоохон шинэ бүс бий болох төдийгүй ЗХА-ийн эдийн засгийн интеграцын нэг томоохон бодит алхам болох юм. Дээрх гурван улсын хүн ам нь нийлээд 1.5 тэрбум болох ба энэ нь дэлхийн хүн амын 1/5 болно. Бүсийн ДНБ нь 12 их наяд ам.доллар буюу дэлхийн ДНБ-ний 20%-ийг эзэлнэ⁸.

⁷www.apec2012.ru

⁸http://mongolian.ruvr.ru/2013_03_28/109224303

ОЛОН УЛС СУДЛАЛ

Хятад улс ийнхүү бүс нутгийн орнуудтай худалдаа, эдийн засгийн олон талт хамтын ажиллагаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ бүс нутгийн хамтын ажиллагаанд Орос улсыг татан оролцуулж тэнд эзэлж буй байр сууриа бататгахыг гол зорилго болгож байна.

Хятад улс НҮБ-ын ивээл дор хэрэгжиж буй “Их Түмэн санаачлага” хөтөлбөрт Оросын оролцоог идэвхижүүлэх, Оростой хил залгаа 3 мужид Оросын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжиж улмаар бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд Хятад, Орос хоёр улс нэгдсэн бодлого, үйл ажиллагаа явуулахыг зорьж байна.

БНХАУ-ын дарга асан Ху Жинтао, ОХУ-ын Ерөнхийлөгч асан Д. Медведев нар “Алс дорнод ба зүүн Сибирийн бүс, Зүүн хойд Хятадын хоорондох 2009-2018 оны хамтын ажиллагааны хөтөлбөр”-ийг, ОХУ-ын Ерөнхий сайд асан В.Путин “Алс дорнод, Байгалийн бүс нутгийг 2025 он хүртэл хөгжүүлэх стратеги”-ийг баталгаажуулсан явдал нь ОХУ, БНХАУ-ын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэслэл болж байна.

“3 жилийн нөлөө, 10 жилийн далайц, 20 жилийн үр дүн” гэсэн олон талт төлөвлөгөөний зарчим нь Орос улс Хятадын Манжуур хотод аж үйлдвэр, худалдааны бүсийг амжилттай байгуулж, хөгжүүлэх, Манжуур хотод төвлөрсөн төмөр зам бүхий олон улсын агуулах барьж байгуулах төлөвлөгөө, 2005-2020 онд Манжуур хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө “Манжуурт Оросын аж үйлдвэрийн болон худалдааны бүсийг 2011-2020 онд байгуулах цогц төлөвлөлт” зэргийг үр дүнтэй хэрэгжүүлэх үндэс болж, улс төр, эдийн засаг, байгаль орчин, нийгэм, хүмүүнлэгийн урт удаан хугацааны туршлага, хамтын ашиг сонирхолд тулгуурласан Орос, Хятадын аж үйлдвэрийн хөгжлийг, хүний хүчин зүйлтэй хослуулсан их бүтээн байгуулалтын хэд хэдэн томоохон Мега төслийг тэнд хэрэгжүүлж эхэллээ.

Хятад, Орос хоёр улс улс төр, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, хүмүүнлэгийн хүрээнд 2020 он хүртэл урт хугацаагаар, олон улсын хууль эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх БНХАУ дахь “Оросын аж үйлдвэр, эдийн засгийн бүс” (Забайкалск-Манжуур боомтоор нэвтрэнэ) төслийн ерөнхий зорилгыг авч үзье. Энэхүү мега төслийн

нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 26,510 тэрбум юань, аж үйлдвэрийн парк байгуулах газрын хэмжээ 800 га, 7080 хүн тэнд ажиллах аж. Төсөлд тусгагдсан жилийн хөрөнгийн эргэлт 38,3 тэрбум юаниас багагүй байх ба жилийн татвар нь 4 тэрбум юань байх аж⁹. Оросын аж үйлдвэрийн цоголборт: Химийн аюултай бодисуудыг боловсруулж, хадгалах үйлдвэр агуулах барих төсөл, Газрын тос, хий, нүүрсний химийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн төсөл, Газрын тос, хий, нүүрсний химийн бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн төсөл гэсэн 3 иж бүрэн цогцолбор мега төслүүд орж байна.

Энэхүү цогцолбор төсөл хөтөлбөр хэрэгжсэнээр Хятад, Оросын харилцааг шинэ шатанд гаргахад хүчин түлхэц өгч, Хятад, Орос хоёр улс Ази Номхон далайн бүс нутаг, Өмнөд болон Төв Америкийг холбосон “шугамын” гол тоглогч болох зорилт биелэлээ олно гэж хоёр тал үзэж байна.

Дөрөв. ЗХА-ийн интеграцид Орос, Хятадын стратегийн түншлэлийн гүйцэтгэх үүрэг

Өнөөдөр Орос, Хятадын стратегийн түншлэл нь бүс нутгийн болон олон улсын тогтвортой байдлыг бэхжүүлэх, бүс нутгийн интеграцийг өдөөх маш чухал хүчин зүйлийн үүрэг гүйцэтгэж байна. Энэ хоёр их гүрний бие биенээ харилцан нөхсөн худалдаа, эдийн засгийн харилцаа хамтын ажиллагаа жил ирэх бүр өсөн нэмэгдсээр байна. 2013 оны байдлаар Хятад-Оросын худалдааны эргэлт 89 тэрбум ам.долларт хүрснээр Хятад улс Оросын худалдааны гол түнш болж улмаар 2015 он гэхэд 100 тэрбум, 2020 он гэхэд 200 тэрбум ам.долларт хүргэх зорилт тавьж байна. 2013 оны байдлаар ОХУ Хятадад 36 тэрбум долларын бараа бүтээгдэхүүн экспортлож, 53 тэрбум долларын бараа бүтээгдэхүүн импортлосон байна.¹⁰ Нийт импортын барааных нь ихэнх нь нэхмэл эдлэл, гар утас гэх мэт орно. Экспортын хувьд мэдээж нэгдүгээрт: эрчим хүчний анхдагч эх үүсвэрийн нийлүүлэлт, хоёрдугаарт зэвсгийн экспорт орж байна. Хятад улсын хувьд Оросын эрчим хүч, эрдэс баялгийн худалдаанд тусгай эрх эдлэхийг хүсч байна.

⁹http://www.gazeta.ru/tags/oao_nk_rosneft.shtml/2012/

¹⁰www.wto.org/Rosstatistics/2014/

ОЛОН УЛС СУДЛАЛ

Африк, Араб, Персийн булангийн орнуудаас далайн тээврээр авч байгаа газрын тосны импорт нь АНУ-тай харилцаа муудсан тохиолдолд найдвартай биш гэж үзэж байна. Стратегийн аюулгүй байдлын үүднээс Бээжин эрчим хүчний эх үүсвэрийн ашигт малтмалыг хуурай газраар дамжуулан Оросоос авахыг илүүд үзэх боллоо. Худалдаа, эдийн засгийн харилцаа хамтын ажиллагааг хөнгөвчлөх зорилгоор хоёр талын төлбөр тооцоонд АНУ-ын доллараас татгалзаж, өөрсдийн мөнгөн тэмдэгтээр хийхээр тохиролцож Оросын хамгийн том банк ВТБ Хятадын төв банктай гэрээ байгуулжээ¹¹.

Худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаанд хөрөнгө оруулалт чухал байр суурь эзэлдэг.

Энэ чиглэлд ч хоёр тал чухал ач холбогдол өгч жил ирэх бүр хөрөнгө оруулалтын томоохон гэрээ хэлэлцээрүүдийг хийсээр байна. Тухайлбал, 2012 оны 4 дүгээр сард Москвад болсон Орос Хятадын дээд хэмжээний уулзалтын үеэр 15 тэрбум ам.долларын томоохон мега төслүүдийг Оросод хэрэгжүүлэхээр тохиролцсон. Хөрөнгө оруулалтын энэхүү төслүүдийг Оросын Алс Дорнод, Номхон далай хавийн эдийн засгийн болон дэд бүтцийн шинэчлэлтэд зориулах юм. Үнэндээ Оросын дээрхи бүс нутгийг Хятад, Япон, Өмнөд Солонгосын хөрөнгө оруулалтгүйгээр хөгжүүлэх боломжгүй гэж судлаачид үздэг. Тийм учраас Алс Дорнодод хөрөнгө оруулалтын нэн таатай орчин бүрдүүлж «татварын диваажин» болгохыг Орос улс зорьж байна. ОХУ-ын засгийн газар Зүүн Сибирь, Алс Дорнодын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх томоохон Мега төслүүдийг 2014-2027 оны хооронд үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилт тавьлаа. Мега төсөл гэж өргөн хүрээг хамарсан их хэмжээний хөрөнгө оруулалт шаардсан төслийг хэлдэг. Мөн хамрах хүрээгээр нь том хэмжээний хөтөлбөр ч гэж нэрлэж болно. Олон Улсын жишигт 1 тэрбум ам доллараас дээш хөрөнгө оруулалт шаардсан төслийг “Мега төсөл” гэдэг бөгөөд тухайн улсын эсвэл бүс нутгийн нийгэм, байгаль орчин, улс төр, эдийн засагт урт хугацаанд эерэг нөлөө үзүүлдэг ач холбогдолтой юм.

Мега төсөл нь ихэвчлэн дэд бүтэц, стратегийн томоохон бүтээн

¹¹ http://Mongolian.ruvr.ru/2013_03_22/108733

байгуулалтийг хамарсан байдаг бөгөөд үүгээрээ олон улс, бүс нутаг, засгийн газрууд, хувийн болон хөгжлийн банкуудийн сонирхлыг татаж, хөрөнгө оруулалтыг шийддэг туршлага нэгэнт бий болсон байна. Дээрхи мега төсөл хөтөлбөрт эхний ээлжинд барагцаалбал 330 тэрбум ам.доллар, цаашдаа 650 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардагдах аж¹². Үүний угтал болгож 2013 онд БНХАУ-ын дарга Си Зиньпины ОХУ-д хийсэн айлчлалын үеэр хоёр улсын хамтын ажиллагааны бүхий л чиглэлийг хамарсан маш чухал багц баримт бичигт гарын үсэг зурсан билээ. Тухайлбал, Оросын томоохон Банк, Шууд хөрөнгө оруулалтын сан, Орос, Хятадын хөрөнгө оруулалтын сан болон Хятадын хөрөнгө оруулалтын нэгдэл Алс Дорнодын дэд бүтэцийн болон бусад томоохон Мега төслүүдэд олон тэрбумын хөрөнгө оруулахаар тохиролцсон. Түүнчлэн Газпромын болон Хятадын China Natural Gas and Petroleum Corporation (CNPC) корпорацийн хооронд Хятадад урт хугацаагаар байгалийн хийг зүүн маршрутаар нийлүүлэхээр тохиролцоонд хүрсэн. Дээрхи гэрээ хэлэлцээрүүдийг эцэслэн тохиролцсон үйл явдал энэ оны 5 дугаар сард болж өнгөрлөө.

Оросын ерөнхийлөгч В.Путины Азид хамтын ажиллагаа итгэлцлийг бэхжүүлэх Шанхайн чуулганд оролцохын сацуу Хятадад хийсэн албан ёсны айлчлал нь дэлхий нийтийн анхаарал татсан айлчлал байлаа. Айлчлалын үер Хятад, Орос хоёр их гүрэн 40 гаруй гэрээ хэлцэл байгуулж, гарын үсэг зурлаа. Өмнө нь Төрийн тэргүүний айлчлалын үеэр хийгдэж байгаагүй олон тооны гэрээ хэлэлцээр байгуулагдаж, Орос, Хятад гэсэн хоёр их гүрэн эдийн засгийн бүхий л салбарт хамтран ажиллахаар боллоо. Товчхондоо бол зөвхөн “Газпром” хятадуудтай улс, төр, эдийн засгийн чухал гэрээ байгуулсан биш, өөр олон салбарын хамтын ажиллагаа айлчлалын үр дүнд сэргэх боломжтой болсон аж. Тухайлбал, Нефть, байгалын хий, аж үйлдвэр, нисэхийн болон авто үйлдвэрлэл, цаашлаад худалдааны борлуулалтын салбарын харилцан хамтын ажиллагааны асуудал ч энэхүү 40 гаруй төрлийн гэрээ хэлцэлд багтжээ. Оросын “Роснефть” компани Тяньжинд нефть боловсруулах үйлдвэрийг ашиглалтад оруулах хугацааны талаар

¹²http://www.gazeta.ru/tags/oao_nk_rosneft.shtml/2014.05/

Хятадтай тохиролцож чаджээ.

Уг үйлдвэрийн цорын ганц түүхий эд нийлүүлэгч нь Оросын компани байхаар гэрээ байгуулжээ. Оросын нефть-химийн “СИБУР” компани, Хятадын нефть, байгалийн хийн “Sinorec” компанитай жилдээ 50 тонн бутадиен-нитрилийн каучук үйлдвэрлэх хүчин чадалтай хамтарсан үйлдвэр байгуулахаар тохиролцож чадсан байна. Хамтарсан үйлдвэрийг Шанхайд босгож, “Sinorec” 74,9 хувь, “СИБУР” 25,1 хувийг нь тус тус эзэмшихээр болжээ. Үйлдвэрийг тэр чигт нь Оросын технологиор барьж гүйцэтгэхээр гэрээнд заасан байна. Айлчлалын үеэр Оросын Гадаад худалдааны банк Хятадын экспорт, импортын банктай зээлийн гэрээ байгуулсан нь Эльгиний нүүрсний ордыг ашиглахад зориулсан 500 сая ам.долларын гэрээ ажээ.

Түүнчлэн “Евроцемент групп” холдинг SINOMA, CNBM, SINOMACH группууд багтдаг Хятадын компаниудтай 500 сая ам.долларын өртөг бүхий гэрээ байгуулсан байна. Гэрээний дагуу, “хуурай” аргаар цемент үйлдвэрлэх үйлдвэрийг Ленинград, Рязаньской, Брянск, Архангельск, Ульяновск, Самар мужуудад босгохоор болжээ. Эдгээр үйлдвэрүүдийн жилд 17 сая тонн цемент үйлдвэрлэх хүчин чадалтай аж. Тун удахгүй Тула мужид Хятадын автын “Great Wall Motors” компанийн үйлдвэр байгуулагдана. Энэ төсөлд 520 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэх ба үйлдвэрийг 2017 онд ашиглалтад оруулж, 2020 онд бүрэн хүчин чадлаар ажиллуулахаар айлчлалын үеэр байгуулсан гэрээнд тусгажээ. Түүнчлэн Оросын нисэхийн үйлдвэрлэлийн нэгдсэн корпораци (ОАК) Хятадын Арилжааны нисэх үйлдвэрлэлийн корпорацитай (Comac) өргөн их биетэй онгоц бүтээх хамтын ажиллагааны тунхаг бичигт гарын үсэг зурав. Түүхий эд, аж үйлдвэрийн салбарт хамаарах гэрээнээс Оросын шууд хөрөнгө оруулалтын сан болон “China Investment Corporation”-ы үүсгэн байгуулсан “Орос-Хятадын хөрөнгө оруулалтын сан” байгуулагдаж, логистик, жуулчлал, өндөр настнуудыг асрамжлах дэд бүтцийн чиглэлд хамтран ажиллахаар тохиролцсоныг талууд онцолж байна. Энэ гэрээний нийт зардал нь нэг тэрбум ам.доллар байхаар заажээ. Улс хоорондын төвшинд байгуулагдсан хөрөнгө оруулалтын хороо нь хамтарсан хөрөнгө оруулалтын асуудлыг үр дүнтэйгээр

шийдэх үүрэг хүлээх ба Оросын тал эдгээр төслүүдийн хөрөнгө оруулалтад гол үүрэг гүйцэтгэх ажээ. Энэ сан нь Амур мөрөн дээгүүр хоёр орныг холбосон анхны төмөр замын гүүр барихад Хятадын түншүүдээс 400 сая ам.долларын хөрөнгө оруулалт оруулж бүтээн байгуулалтын ажлыг гардан хийх юм байна. Гүүрийн ажлыг ойрын хугацаанд эхлүүлж, 2016 онд ашиглалтад өгөхөөр заажээ. Өөр нэг онцлох гэрээ нь Оросын төмөр зам РЖД болон “Хятадын төмөр зам”-ын хооронд байгуулсан Стратегийн хамтын ажиллагааны гэрээ юм. Дээрх компаниуд хоёр орныг холбосон дэд бүтцийг хөгжүүлж, төмөр замын тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах ажээ. Энэ мэтчилэн Орос, Хятадын томоохон компани, төлөөллүүдийн дунд байгуулсан олон гэрээг дүгнэн шинжээчид “Путины айлчлалыг хоёр талд харилцан ашигтай худалдаа, эдийн засгийн харилцааны хувьд чухал айлчлал боллоо” хэмээн онцолж байна. Гэсэн хэдий ч айлчлалын хамгийн чухал амжилт нь яах аргагүй Оросын байгалийн хийг Хятадад нийлүүлэхээр гэрээ байгуулсан явдал юм. Оросын “Газпром” Хятадын CNPC хоёрын байгуулсан гэрээний дагуу 30 жилийн хугацаанд Орос жилдээ 38 тэрбум шоо метр хийг Хятадад нийлүүлэх гэрээний нийт өртөг 400 тэрбум ам.доллар байх ажээ¹³.

2013 оны байдлаар Оросын Газпромын хийн нийлүүлэлтийн үнэ Европт дунджаар мянган шоо метр нь 380 ам.доллар байсан. Зарим судалгааны байгууллага, тухайлбал CLSA-ийн тооцоогоор Хятад руу нийлүүлэх хийн үнэ мянган шоо метр тутамд 330-350 доллар байх магадлалтай¹⁴ гэсэн таамаглал дэвшүүлж байсан нь батлагдаж Орос улс үнэ дээрээ буулт хийж, мянган шоо метр тутамд 350 ам доллар байхаар тохиролцжээ. Ийнхүү бүхэл бүтэн арван жилийн өмнө эхэлж, зургаан жил зарцуулж байж сая л нэг үнэ ханшин дээрээ тохиролцож чадлаа. Одоо гэрээ ёсоор Якут-Хабаровск-Владивосток гэсэн 61 тэрбум шоо метр хий дамжуулах хүчин чадалтай “Сибирийн хүч” дамжуулах хоолойноос Хятадад гаргах салаа байгуулан, Оросын байгалийн хийг нийлүүлнэ. “Сибирийн хүч” хийн хоолой нь Якут, Эрхүүгийн хийн

¹³http://www.gazeta.ru/tags/oao_nk_rosneft.shtml/2014.05/

¹⁴<https://www.clsa.com/> /CLSA is Asia's leading equity brokers and investment groups focused on institutional broking, investment banking and asset management to corporate and institutional clients around the world/.

ОЛОН УЛС СУДЛАЛ

олборлолтын төвүүдийг холбож, Хабаровскаар дамжин Владивосток хүрэх ба тэндээс Хятад руу хий дамжуулах хоолойг салгах ажээ. Логикоор бол Хятад хийн хоолой барихад зориулж урьдчилгаа мөнгө өгөх ёстой. Урьдчилан тооцоолж байгаагаар бол хоолой байгуулах нийт зардал 35-40 тэрбум ам.доллар байх бол ийм урт хоолойг барихад 3,5 жил орчим хугацаа шаардлагатай ажээ. “Газпром” хийн хоолой байгуулах ажлыг хурдасгах зорилгоор Хятадаас 25 тэрбум ам.долларын урьдчилгаа авахаар тохиролцсон байна. Хоёр тал нийлүүлэлтийг 2018 оноос эхлэх зорилт тавьж байна. Дээрхи гэрээний дагуу Орос Хятад улсад жилд 38 тэрбум шоо метр хий нийлүүлэх хэмжээг тогтоосон хэдий ч цаашид 60 тэрбум хүртэл нэмэгдүүлэх боломжтой аж. Шинжээчдийн тооцоолсноор 2020 онд Хятадын хийн хэрэглээ жилд 300-350 тэрбум шоо метр болох аж. Өнөөгийн байдлаар Хятад өөрсдөө 115 тэрбум шоо метр хий олборлодог. Мөн худалдан авсан шахмал хийгээр 80 тэрбум орчим шоо метрийн хэрэглээгээ тэд хангана. Ази, Номхон далайн бүсийн орнуудаас Хятадад нийлүүлж байгаа хийн хэмжээ нь 40 тэрбум шоо метрээс хэтрэхгүй. Алсдаа Хятадын хийн хэрэглээ нь 2030 онд өнөөгийн Европын хэрэглээний 600 тэрбум шоо метрийн хэмжээнээс давж гарах ажээ¹⁵.

Москва, Бээжингийн харилцааны талаар 2013 онд Орос улсад хийсэн айлчлалын үер Си Зиньпин хэлэхдээ “үүрд мөнхийн анд нөхөд, хэзээч дайсан байгаагүй гэсэн” хэллэгээр тодорхойлсон бол ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путин “Бид БНХАУ-ын даргатай худалдаа-эдийн засгийн, хүмүүнлэгийн болон бусад харилцан ажиллагааны хэлхээ холбоогоо цаашид хөгжүүлэхийн тулд бүхий л бололцоогоо дайчлахаар тохиролцсон.

Цаашид бүс нутгийн болон олон улсын хэргүүдийг зохицуулахдаа хийх алхмуудаа нягтлаж байх болно”¹⁶ хэмээн тодотгосон. Тэрээр цааш нь “Орос, Хятадын хоорондын харилцаа нь ямар нэгэн атгаг санаа болон стереотип үгүй, тэгэхлээр туйлын бат бэх бөгөөд аливаа олон улсын түр зуурын үйл явдлуудад автагдахгүй. Энэ нь тогтвортой байдал болон харилцан итгэлцэл хомсдох болсон өнөөдрийн нөхцөлд үнэ цэнэтэй юм.

¹⁵http://www.carnegiet.sinhua.org/Wang_Tao_Q&A_March_17,_2014

¹⁶http://mongolian.ruvr.ru/2013_03_22/1087339

Орос-Хятадын харилцаа нь улс хоорондын хэлхээ холбооны шинэ төрлийн үлгэр жишээ болж, Москва, Бээжин хоёр нийтлэг эрх ашгаа нэгтгэж, харилцан ойлголцож, нэгдсэн тактик боловсруулсанд оршино”¹⁷ гэж дэлхий дахинаа тунхагласан билээ.

Ийнхүү Орос улс Хятадын стратегийн түншлэл хүссэн хүсээгүй энэ бүс нутагтай холбогдож, нягт хамтран ажиллах замаар бүс нутгийн интеграцийг идэвхижүүлж, тэнд хоёр улс голлон тоглогч болох нэгэн зорилго тэднийг нэгтгэж байна.

Бүс нутгийн орнууд ч гэсэн сүүлийн үед Хятадын шинэтгэлийн загалмайлсан эцэг Дэн Сяопины «нутаг дэвсгэрийн асуудлыг хойч үеийнхэнд үлдээх» гэрээсийг хүндэтгэн ойрын үед дэлхийн эдийн засгийн тэргүүлэх төв болох угтвар нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого үйл ажиллагаа явуулж эхэллээ.

Дүгнэлт

ЗХА дахь Орос-Хятадын стратегийн түншлэл бол энэ бүс нутгийн ирээдүйн хөгжил цэцэглэлтэд зарчмын ач холбогдолтой юм. Хоёр улсын хамтын ажиллагаа ерөнхийдөө Номхон далай дахь АНУ-ын цэргийн ноёрхолыг саармагжуулахад чиглэж байгаа ч улс орны хөгжлийн асуудлыг гол цөмөө болгож буй хоёр улсын удирдлагын стратегийн зорилгоос үүдэлтэй. Тиймээс бид ЗХА-ийн интеграцид нэгдэхийн тулд бодлого үйл ажиллагаагаа энэ хоёр улстай уялдуулан зохицуулж байж л амжилтад хүрнэ. Энэ үүднээс авч үзвэл бид гурван улсын нэгдсэн бодлого буюу «Гурвалжин харилцаа»-г эрхэмлэж, энэ хоёр улстай илэн далангүй ярьж, ойлголцох асуудал шийдвэрлэх үүрэг рольтой.

Орос-Хятадын энэхүү аядуу зөөлөн хамтын ажиллагаа Монгол улсын өнөөгийн болон алс хэтийн хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд гадаад талын шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Ийм нааштай хамтын ажиллагаа хэдий хүртэл, хэр удаан үргэлжлэхийг хэлэхэд хэцүү. Юутай ч үүлэн чөлөөний энэхүү нарыг ашиглаж, өөртөө

¹⁷http://mongolian.ruvr.ru/2013_03_28/10922430

ОЛОН УЛС СУДЛАЛ

ашиг хонжоо олох явдал Монгол улсын оршин тогтнохын чухал нөхцөл мөн. Гэвч энэ бол жичдээ сэдэв юм.

Ном зүй

1. www.wto.org/english/res_e/publications_e/world_tariff.
2. www.worldenergyoutlook.org/media/weowebiste/2013
3. Ulyana SHIPITKO Rediscovering Russia in Northeast Asia / Ritsumeikan Annual Review of International Studies, 2012. ISSN 1347-8214. Vol.9,
4. www.worldbank.org/en/region/eap/East Asia, Pacific statistic
5. www.apec2012.ru
6. http://mongolian.ruvr.ru/2013_03_28/109224303
7. <https://www.clsa.com/>
8. <http://www.carnegiet sinhua.org./Wang Tao Q&A March 17, 2014>